



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 1,180,375,537.12 (нэг тэрбум нэг зуун наян сая гурван зуун далан таван мянга таван зуун гучин долоон төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 718,026,939.74 (долоон зуун арван найман сая хорин зургаан мянга есөн зуун гучин есөн төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Тогтоолын хавсралтад заасан төрийн өмчит байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, үнэ шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашины төлбөр хураамжийг төлж, автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн
262 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэр-лэсэн/Ашиг-лаптад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Хүлээлгэн өгсөн байгууллагын нэр
1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Ниссан Патрол Y-61	00-64 УБВ	JN1TFSY61Z0570206	2015/2015	53,152,000.00	35,434,439.62	17,717,560.38	Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
2	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Ниссан Патрол Y-61	00-36 ОРХ	JN1TFSY61Z0570199	2015/2015	53,152,000.00	35,434,439.62	17,717,560.38	Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
3	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Ниссан Патрол Y-61	08-49 ОРХ	JN1TFSY61Z0570207	2015/2015	53,152,000.00	35,434,439.62	17,717,560.38	Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
4	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Тоёота ланд круйзер 200	44-88 УНР	JTMNHU09J4B4035350	2011/2011	120,003,669.05	120,003,669.05	-	Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
5	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Тоёота ланд круйзер 200	03-09 УБР	JTMNHX05J004169136	2018/2018	228,127,272.73	126,408,466.53	101,718,806.20	Дорнод аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
6	"Эрдэнэс таван толгой" ХК	Ниссан Патрол Y-62	55-61 УАА	JN1TANY62Z0110575	2019/2019	225,000,000.00	100,782,618.46	124,217,381.54	Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт

7	"Эрдэнэс таван толгой" ХК	Рэнаулт Аркана	98-72 УАВ	X7LRJC4D9642 36714	2019/2019	89,000,000.00	34,116,666.66	54,883,333.34	Өвөрхангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
8	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ	Тоёота ланд круйзер 76	21-71 УНЗ	JTEEB71J50702 4085	2014/2014	147,200,000.00	133,612,406.68	13,587,593.32	Хэнтий аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
9	"Монголын төмөр зам" ТӨХК	Тоёота ланд круйзер 76	01-66 УАВ	JTEEB71J00F0 04039	2019/2019	103,765,123.34	2,584,896.31	101,180,227.03	Архангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
10	"Таван толгой төмөр зам" ХХК	Тоёота ланд круйзер 200	27-22 УБГ	JTMDU09J7E50 86970	2014/2014	107,823,472.00	94,214,897.19	13,608,574.81	Завхан аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт
Нийт дүн						1,180,375,537.12	718,026,939.74	462,348,597.38	
						(нэг тэрбум нэг зуун наян сая гурван зуун далан таван мянга таван зуун гучин долоон төгрөг арван хоёр мөнгө)	(долоон зуун арван найман сая хорин зургаан мянга есөн зуун гучин есөн төгрөг далан дөрвөн мөнгө)	(дөрвөн зуун жаран хоёр сая гурван зуун дөчин найман мянга таван зуун ерэн долоон төгрөг гучин найман мөнгө)	

Нийт дүн